

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариалан НАҮТ ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/016/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Мөрөн сум
2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа
Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com
Аудитор Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793. Цахим шуудан: khuvsagul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 1/312
танай _____-ны № _____-т

ТАРИАЛАН НИЙТИЙН АХУЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.БОЛДОО ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тариалан нийтийн ахуйн үйлчилгээний төв ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн И/13 тогтоолоор компанийн өмчлөлийг Тариалан сумын ИТХ-д шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 251,153.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 251,153.6 мянган төгрөгийн 8 алдааг залруулж, нийшлийн аудиттай холбогдолтой 4 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлээ.

Бусад асуудлын хэсэг

Тариалан нийтийн ахуйн үйлчилгээний төв ХХК-ийн тайлант жилийн орлогын төлөвлөгөө 11.6 хувиар давж, зардлын төлөвлөгөө 15.1 хувиар хэтэрч, 29,638.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,211,966.47	1,610,810.60
1.1.2	Дансны авлага	36,649,911.02	62,113,341.90
1.1.4	Бусад авлага	60,000,000.00	-
1.1.6	Бараа материал	72,395,810.85	97,492,281.10
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	177,257,688.34	161,216,433.60
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,116,847,467.08	1,272,113,418.26
1.2.2	Биет бус хөрөнгө	22,171,720.00	22,171,720.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,139,019,187.08	1,294,285,138.26
1.3	Нийт хөрөнгийн дүн	1,316,276,875.42	1,455,501,571.86
2.1.1.1	Дансны өглөг	44,912,414.14	107,615,806.71
2.1.1.3	Татварын өр	27,079,377.33	51,444,073.84
2.1.1.4	НДШ - ийн өглөг	655,066.00	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	72,646,857.47	159,059,880.55
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	45,903,874.29	45,903,874.29
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	45,903,874.29	45,903,874.29
2.2	Өр төлбөрийн нийт дүн	118,550,731.76	204,963,754.84
2.3	Өмч	367,132,300.00	367,132,300
2.3.2	-хувийн	367,132,300.00	367,132,300.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	635,114,945.95	635,114,945.95
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	375,662,399.00	463,112,399.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(180,183,501.29)	(214,821,827.93)
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,197,726,143.66	1,250,537,817.02
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	1,316,276,875.42	1,455,501,571.86

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	830,175,796.80	1,016,488,522.62
2	Борлуулалтын өртөг	837,190,218.90	951,754,997.42
3	Нийт ашиг (алдагдал)	-7,014,422	64,733,525.20
10	Ерөнхий ба удирдлагын зардал	80,271,099.90	85,450,314.00
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		8,921,537.84
17	Бусад ашиг (алдагдал)	5,935,171.60	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-81,350,350	-29,638,326.64
19	Орлогын татварын зардал		-
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	-81,350,350	-29,638,326.64
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-81,350,350	-29,638,326.64
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	-81,350,350	-29,638,326.64

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	367,132,300.00	668,998,445.95	334,530,399.00	-127,716,650.92	1,242,944,494.03
2	Тайлант үеийн цэвэр				-81,350,350.37	-81,350,350.37

	ашиг (алдагдал)					
3	Өмчид гарсан өөрчлөлт			41,132,000.00		41,132,000.00
4	Зарласан ногдол ашиг				-5,000,000.00	-5,000,000.00
5	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-33,883,500.00		33,883,500.00	33,883,500.00
6	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	367,132,300.00	635,114,945.95	375,662,399.00	-180,183,501.29	1,197,726,143.66
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-29,638,326.64	-29,638,326.64
8	Зарласан ногдол ашиг				-5,000,000.00	-5,000,000.00
9	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			87,450,000.00		87,450,000.00
10	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	367,132,300.00	635,114,945.95	463,112,399.00	-214,821,827.93	1,250,537,817.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
1.1	Мөнгөн орлогын дүн	961,039,266.30	1,090,176,541.79
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	960,488,715.30	1,090,176,541.79
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.6	Бусад мөнгөн орлого	550,551.00	
1.2	Мөнгөн зарлагын дүн	889,384,543.98	996,490,197.66
1.2.1	Ажиллагчдад төлсөн	228,403,459.00	280,340,132.06
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	75,283,082.82	82,480,205.35
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	202,585,317.00	151,129,713.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	106,290,476.00	114,981,479.53
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	173,572,488.40	279,584,565.50
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	60,821,936.51	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	20,839,900.00	46,963,025.25
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		61,425.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	42,427,784.25	40,949,651.97
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	71,654,722.32	93,886,344.13
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	60,000,000.00	95,487,500.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	60,000,000.00	95,487,500.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(60,000,000.00)	(95,487,500.00)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	9,411,888.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		9,411,888.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	5,000,000.00	14,211,888.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		9,211,888.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	5,000,000.00	5,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,000,000.00)	(4,800,000.00)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	6,654,722.32	(6,601,155.87)
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	1,557,244.15	8,211,966.47
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	8,211,966.47	1,610,810.60

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

№	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувиар
1	Халаалтын орлого	827,386,624.00	900,198,217.31	72,811,593.31	108.80
2	Цэвэр усны орлого	47,161,692.00	51,853,354.73	4,691,662.73	109.95
4	Халуун усны орлого	13,785,256.00	11,358,314.22	(2,426,941.78)	82.39
5	Хогны төлбөрийн орлого	14,581,184.00	50,262,727.27	35,681,543.27	344.71
6	Түрээсийн орлого	2,592,000.00	2,009,090.91	(582,909.09)	77.51
7	Бусад орлого	5,500,000.00	806,818.18	(4,693,181.82)	14.67
	Орлогын дүн	911,006,756.00	1,016,488,522.62	105,481,766.62	111.58
1	Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал	306,050,141.15	327,883,422.00	21,833,280.85	107.13
2	НДШимтгэлийн зардал	41,316,769.05	44,120,485.21	2,803,716.16	106.79
4	Шатахуун	30,283,200.00	33,798,038.92	3,514,838.92	111.61
5	Нүүрсний зардал	96,772,500.00	89,221,375.00	(7,551,125.00)	92.20
5	Тээврийн зардал	170,100,000.00	252,913,524.70	82,813,524.70	148.69
6	Гэрэл цахилгаан	95,856,128.64	101,984,981.39	6,128,852.75	106.39
7	Бичиг хэрэг	807,750.00	807,750.00	-	100.00
8	Цахилгаан холбоо	1,190,400.00	1,190,400.00	-	100.00
9	Албан томилолт	1,064,000.00	1,064,000.00	-	100.00
10	Цэвэрлэгээний материал	12,068,100.00	12,068,100.00	-	100.00
11	Хөдөлмөр хамгаалал	18,457,920.00	18,457,920.00	-	100.00
12	Урсгал засвар	0.00	11,048,436.36	11,048,436.36	
13	Төлбөр хураамж	11,034,000.00	11,034,000.00	-	100.00
14	ТУЗ зардал	5,696,000.00	4,306,900.00	(1,389,100.00)	75.61
	Туз НДШ	594,000.00	495,293.50	(98,706.50)	83.38
15	Түлээний зардал	3,150,000.00	3,150,000.00	-	100.00
16	Хор саармагжуулах ундаа	3,780,000.00	3,780,000.00	-	100.00
17	Сэлбэгийн зардал	8,802,000.00	8,802,000.00	-	100.00
18	Үйлчилгээний тохижилт	4,738,500.00	4,738,500.00	-	100.00
19	Ажилчдын нийгэм хангамж	6,610,000.00	7,510,000.00	900,000.00	113.62
20	Сургалтын зардал	0.00	3,129,008.37	3,129,008.37	
21	Тэтгэвэр тэтгэмжийн зардал	6,701,160.00	7,951,160.00	1,250,000.00	118.65
22	Нийгмийн хариуцлагын хүрээнд	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
23	Ноогдол ашиг	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
24	Элэгдлийн зардал	74,000,000.00	86,671,553.81	12,671,553.81	117.12
27	Нийт үйл ажиллагааны зардлын дүн	909,072,568.84	1,046,126,849.26	137,054,280.42	115.08
29	Татварын өмнөх ашиг, /алдагдал/	1,934,187	(29,638,326.65)	(31,572,513.65)	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 251,153.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг аудитын явцад 251,153.6 мянган төгрөгийн 8 алдааг залруулж, нийцлийн аудиттай холбогдолтой 4 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайлан буруу илэрхийлсэн 105,534.5 мянган төгрөгийн алдаа залруулсан.
- Дансны бичилт буруу 96,558.0 мянган төгрөгийн алдаа залруулсан.
- Борлуулалтын орлоготой холбоотой 49,061.1 мянган төгрөгийн авлага залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг алдаа, зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Тариалан НАҮТ ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 12 сарын 26-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан 2024 оны бизнес төлөвлөгөөний зардлыг 137,054.3 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж,

зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;" гэж заасныг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Ахмадын сангийн талаар

Илрүүлэлт:

Тариалан НАУТ ХХК нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах..." гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах.

2. И-баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материал, үндсэн хөрөнгө худалдан авалттай холбоотой 128,133.5 мянган төгрөгийн гүйлгээ нь цахим и-баримтгүй байгаа нь Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13-р зүйлийн 13.1.4; "доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх" заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 зааснаар бараа материалын худалдан авалтыг дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар анхан шатны баримт бүрдүүлж хэвших.

3. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 15, зарлагын 22 гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2.10. "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" нийтэд мэдээлнэ заалттай нийцэхгүй бөгөөд Шилэн дансны тухай хууль, тогтоомжид нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-д заасан хугацааг баримтлан мэдээлж байх.

4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3,20.4 заалтад заасан ТУЗ-ийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалттай холбоотой мэдээлэл, гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэр, тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээллийг ил тод, цахим хуудсаар мэдээлээгүй.

Өгсөн зөвлөмж:

Хууль, журамд заасан мэдээллүүдийг ил тод, цахим хуудсаар мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлан буруу илэрхийлсэн 105,534.5 мянган төгрөг	5	105,534.5			5	105,534.5	5	105,534.5		
Дансны бичилт буруу 96,558.0 мянган төгрөг	2	96,558.0			2	96,558.0	2	96,558.0		
Борлуулалтын орлоготой холбоотой залруулга	1	49,061.1			1	49,061.1	1	49,061.1		
Дүн	8	251,153.6			8	251,153.6	8	251,153.6		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2024 оны бизнес төлөвлөгөөний зардлыг 137,054.3 мянган төгрөгөөр хэтрүүлсэн	1	0			1	0		
Шилэн дансанд мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан.	1	0					1	0
Худалдан авалттай холбоотой 128,133.5 мянган төгрөгийн ажил гүйлгээ нь и-баримтаар баталгаажуулаагүй.	1	0					1	0
Ахмадын сан байгуулаагүй байгаа	1	0					1	0
Төрийн хэмнэлтийн хуулийн 20-р зүйлд заасан мэдээллийг ил тод, цахимаар мэдээлээгүй.	1	0					1	0
Дүн	5	0			1	0	4	0



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

№ 72/АА270469/

Мөрөн сум

ХАА - 2025/010 / ИА - СТА - 010117

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Тариалан НАҮТ ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тариалан НАҮТ ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 12 сарын 28-ний өдрийн 14, 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 01 дүгээр тогтоолуудаар баталсан 2024 оны бизнес тодорлогоөний нийт зардлыг 137.054.3 мянган төгрөгөөр хэтрүүлсэн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө бсловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гэрээуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.5-т "төсвийн орлого, зарлагыг буруу тооцолсон төсвөт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Компанийн бизнес төлөвлөгөөг үндэслэлтэй тооцож батлуулан биелэлтийг хангах, батлагдсан зардлын хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор оруулж, баталгаажуулах;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тариалан НАҮТ ХХК-ийн захирал Г. Болдоо, нягтлан бодогч Б. Мөнхцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А. ЭРДЭНЗБААТАР

АУДИТОР

Т. ИЧИНХОРЛОО



6724070623